



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4-р сарын 27 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Мон-Гео ХК-ийн дүрмийн 6,7 дахь заалт, Хувьцаа Эзэмшигчдийн 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хуралдсан ээлжит хуралд оролцсон Хувьцаа эзэмшигчдийн санал нэгтэй зөвшөөрснийг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Нэг. Компанийн 2024 оны санхүүгийн жилийн тайланг зөвшөөрсүгэй.

Хоёр. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг хүлээн авсугай.

Гурав. Аудиторын дүгнэлтийг зөвшөөрч зөвлөмжид өгүүлсэн ажлыг хэрэгжүүлэхийг / ня-бо/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр зарлагдсан сонгон шалгаруулалтад шаардлагатай тооцоо төсвийг хийж, шийдвэрийг батлуулж оролцсугай.

Тав. Хурлын тооллогын комиссийн шийдвэрийг үндэслэн Б.Доржмягмарыг компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсныг батламжилсугай.

Зургаа. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн чадамжийг өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.

Долоо. Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн нутагт байрлалтай 8.08 га газрыг үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах, бусдад түрээслэх, төсөл төлөвлөгөөт ажлыг зохион байгуулахыг компанийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Найм. Компанийн санхүү, эдийн засгийн чадамжийг сайжруулах, өргөжүүлэх зорилготойгоор салбар харгалзахгүйгээр бизнес төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-ийн хурлаар баталгаажуулан хяналттай, хугацаатай, шат дараалан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Ес. Компанийн Гүйцэтгэх захирал М.Алтанцэцэгийг улираан ажиллуулсугай.

Хурлын дарга.....Н.Соёмбо

Хурлын нарийн бичгийн дарга.....Н.Тулга



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4-р сарын 27 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ердийн гишүүнд сонгогдсон тооцох тухай

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 27-ны ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэр, хуралд оролцсон гишүүдийн 41887 ширхэг хувьцаа буюу 251322 ширхэг саналын эрхийг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Кумулятив аргаар явагдсан ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал хураалтаар 41887 ширхэг санал авсан Батбаяр овогтой Доржмягмарыг компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсонд тооцсугай.



Хурлын дарга.....Н.Соёмбо

Хурлын нарийн бичгийн дарга.....Н.Тулга



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 1-р сарын 27 өдөр

Дугаар 3

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН КОМИССИЙН ШИЙДВЭР

Хувьцаа Эзэмшигчдийн 2025 оны ээлжит хурлын саналын хуудасны тоог үндэслэн хэлэлцэх ажлуудал бүрийг нийт саналын тоогоор батлав.



Тооллогын комиссийн дарга.....Н.Бат-Өлзий

Гишүүн.....Г.Даваажаргал

Гишүүн.....Б.Түмэнжаргал